

# НҮҮДЭЛЧНИЙ СОЁЛЫН ТУХАЙ ЭРЭГЦҮҮЛЭХ НЬ

Хэрэйд ШАРАЛДАЙ<sup>1</sup>

## 1. СОЁЛЫН ТУХАЙ

Хүн бол соёлт оршихуй юм. Соёлыг зөв тодорхойлбол, хүний нийгмийн тухай тодорхой ойлголттой болно. Түүхэн дэх нийгмийн ухааны судлалд хүнийг соёлоос нь салган үздэг байснаас дандаа тонгорсон дүгнэлт гаргасаар иржээ.

Соёлыг зарим тольд “Дэлгэрэнгүй утга нь хүн төрөлхтний түүхэн явцад бүтээсэн эдийн болон оюуны баялагийн нийлбэр. Явцуу утга нь нийгмийн ухамсар болон түүнтэй зохицсон ёс журам, байгууламж юм” хэмээн тайлбарласан байхад зарим номд “Соёл бол хүн төрөлхтний нийгмийн явцад бүтээсэн бүхэл зүйл”, “Соёл бол аливаа нийгмийн бүхий л амьдралын арга маяг” гэж томъёолсон байхад олон хэвлэл нийтлэлд цэнгэлийн соёл, дайны соёл, зэвсгийн соёл, бурхны соёл, чөтгөрийн соёл, архины соёл, цайны соёл, тамхины соёл, хувцасны соёл, заслын соёл, идээний соёл, хурьцлын соёл цаашилбал жорлонгийн соёл гэхчлэн бараг бүх л юм бүр соёл болчихоод удалгүй булааж дээрэмдэх соёл, хулгайлж худал хэлэх соёл, янхлах хүчиндэх соёл хэмээн нэрийдэхэд ойрхон болоод байна. Яагаад гэвэл юм бүхэн “Соёл” болчихсон байхад “Амьдралын арга маяг” шүү дээ гэж хариулна байх. Монгол толь бичгүүдэд “Эрдмээр хөхүүлэн хөгжүүлэхийг соёл хэмээмүй”, “Гал махбодиор хатуугийн зүйлийг гэсгээх адил, эрдмээр эгэл мэдлийг гэгээрүүлснийг соёл хэмээмүй”, “Гайхамшигийг мохоож, соёлыг мэдсэн нь эрдмийн эрхэм нь болой” гэж тайлбарласан байна. Үүнийг соёлын ..ийгэмч, ангич, адил бус, нэвчих, залгамжлах, холимог, задгай, үл халдварлах чанар гэхчлэн өнгөн талаас нь мэдэмхийрсэн яриаг бодвол соёлын мөн чанартай ойртсон нотлол гэлтэй.

Хүн төрөлхтөн бол соёлт оршихуй, соёл хэмээгч ганцхан хүн төрөлхтөнд хамаатай оюуны бүтээгдэхүүн, оюуны хүчин мөн. Хүн төрөлхтөн зөвхөн соёлоороо адгууснаас ялгардаг. Соёл бол ганцхан мэдлэгээр хязгаарлагдах юм биш. Соёлд мэдлэгийн, оюуны соёл гэх хоёр том ялгаа байдаг. Товчоор хэлбэл соёл бол хүний сэтгэл оюуны тухайн үндэстний сүлд сүнс орших орон мөн. Гагцхүү соёл сая хүнийг аврах увьдаст хүчин мөн. Иймээс соёлжих явдал бол нэг хүн нэг үндэстний оршин тогтнохын хувь заяатай шууд холбогдох явдал мөн. Хүн төрөлхтөн хэдийгээр саранд авиран, сансарт аялах, болсон ч соёлын төвшинд тэмүүлсээр байна. Оюуны соёл бол дотоод сэтгэлийн гэгээрлийн туйл ариусган цэвэршсэн гэгээн сүнс, билиг

<sup>1</sup> БНХАУ-ын ӨМӨЗО-ны Чингис судлалын эрдэмтэн

нээлтийн жинхэнэ биелэл мөн. Эдүгээ ертөнц дээр хатуу бясалгалаар шидийг олсон цөөхөн хүмүүсийг гаргавал хар тэргүүтнүүдийн ихэнх нь эд мөнгөнд шунахайран амьдралын бурангуй тоосонд дарагджээ. Ийнхүү хүн төрөлхтөн саяхнаас оюуны соёлыг анхааралдаа авдаг боллоо.

Гэтэл нүүдэлчин монголчууд XIII зууны үед оюуны соёлын ид шидийг ухааран хэрэгжүүлж ирсэн түүхтэй билээ. Тухайн үеийн монголчууд “мөнх тэнгэр” шүтлэгийг сонгон авч орчлон ертөнц тухайлбал тэнгэр хүний хоорондох захирах захирагдах хатуу хуулийг туйлбартай хэрэгжүүлж байсан цаг үе юм. Чингис хаанаас хойших хаадууд тэнгэр шүтлэгээ хаячаад харь шажнаар сүнсээ хөтлүүлэх болсноос монгол нь монгол биш болж “Хөтлөхийн дээд хөх монгол” гэгч нь харийн юмсаар хөтлүүлэх болж магнай дээр нь бусдын борвины тоос бууж, “Хишиг буян” тогтохоос өөр хувь заяа үгүй болсон билээ.

Хүн төрөлхтний соёлыг байршил байдлаар нь ангилбал өрнөдийн хөгжингүй дөрвөлжин соёл /дорно дахины хөгжингүй бус дөрвөлжин соёл багтана/ монголын өндөрлөгийн дугуй нүүдэл соёл хэмээн хоёр том төрөлд хувааж болно.

Хөгжингүй дөрвөлжин соёл нь хүний мэдэхүй чадахүй чадварыг дээд хэмжээгээр бадруулан, шинжлэх ухааны шинэ мэргэжлийг нийгэмд эзэмшүүлэн ашигласнаас эдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ноён оргилд нь хүргэжээ хэмээн хэлж болно. Энэ бол хүмүүсийн үзэл санааг харгис хэрцгийгээр хүлээсэлж байсан феодал ёсноос чөлөөлсөн асар их амжилт бүтээл мөн. Хөгжингүй бус дөрвөлжин соёлтонгуудын зорилт нь мөн хөгжингүй болох явдал болохоор тусад нь тайлбарлах шаардлагагүй юм.

Дөрвөлжин соёл бол хүмүүс өөрснөө бүтээсэн зохиомол зүйл болно. Дөрвөлжин гэдэг нь оршин суудаг байр байшин, өрөө тасалгаа нь дөрвөлжин, ширээ сандал, унадаг унаа, авдар шүүгээ, барьдаг багаж, сав хэрэгсэл нь дөрвөлжин, ном хэвлэл зарим үсэг бичиг нь ч дөрвөлжин гэхчилэн цөм дөрвөлжин хэлбэртэй, хамгийн гол нь дөрвөлжин бүтээлийг бүтээгчид нь дөрвөн ханатай нүхэнд шургачаад дөрвөлжин цонхоор орчлон ертөнцийг ажиж өсч торнидог болохоор хүмүүсийн сэтгэхүйн загвар нь ч хавтгай дөрвөлжин шинж төлөвтэй байдгаараа онцлогтой. Дөрвөлжин соёлтонгууд өөрийн амьдрах орчноо элбэг дэлбэг эд эрдэнэсээр чимэглэн эгэл биетнийг биеэс нь хэтэрсэн эд мөнгө хөөцөлдөх ёроол үгүй шунал руу хөтлөн ямар ч гарах зам үгүй мухар гудамж руу оруулчихдаг. Иймэрхүү орчинд ихэнх хүмүүс нь хөгжингүй нийгэм дэх “хулганы нүд”-ээр хорвоо ертөнцийг аждаг мунхагууд болон хувирдаг байна. Иймээс тэд нар өөрсдийн “хөгжил”-ийнх нь өмнө давж туулшгүй том “архаг өвчин” байдгийг сэхээрч мэдрэх оюуны тэнхээ сулхан байдаг. Тухайлбал:

Нэг, дөрвөлжин соёлын орчин бол маш хатуу, шаардлага бүхий чухамхүү энэрэлгүй хорвоо юм. Энэ орчинд хэдийгээр “эрх чөлөө”, “ардчилал”, “хүний эрх”, “түгээмэл хайр” гэх мэтийн сайхан уриа, мэргэн цэцэн сургаал үгс, хууль цааз байдаг ч хэрэг дээрээ энэ орчинд эд мөнгөтэй,

эрх тушаалтай хүмүүсээс бусад эгэл жирийн хүмүүс амьдрахын аргагүй юм. Учир нь дөрвөлжин орчинд хүний амьдралын үндэс нь мөнгө болохоор “Баячууд нь язарч, ядуучууд нь өлбөрч үхмээр”, “тэрэгтэй нь тэрхэрч, тэрэггүй нь мөлхдөг орчин”, “зоостой хүнд жаргалангийн орон, зоосгүй хүнд тамын орон” гэгчийг хамгийн хөгжсөн улсын хамгийн шалгарсан ерөнхийлөгч ч хувиргаж чадахгүй юм.

**Хоёр.** Дөрвөлжин орчинд эд бодисын гоё цэвэр, мэргэжлийн шинэ төхөөрөмжөөр, хүмүүс ялангуяа өсвөр багачуудын сэтгэл оюуныг бохирдуулдаг нь энгийн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, ямарч соёл оюуны утга агуулгагүй юмсаар түмэн бузрыг түгээсээр байгаад хүнийг хүн биш болгочихдог орчин юм. Тухайлбал, дэлхийн ямарч хот-дөрвөлжин орчинд чихэнд сонсдож нүдэнд харагддаг дохио тэмдгүүд нь хүний оюунд тус нэмэр болмоор юм тун ховор. Ном судар, сонин сэтгүүл ч хуудас дүүрэн худал үт биш бол хоосон үг байдгаас хүмүүсийн оюуныг ундлан тэжээж тэтгэх зүйл тун ховор байдаг.

Эдгээр нь оюуны хатуу бясалгалаар орчлон ертөнцийн үнэн мөнийг таньсан шидтэнд юу ч биш боловч энгийн хүмүүс ялангуяа өсвөр бага насны залуучуудад туйлын сөргөөр нөлөөлж, хүн болох замыг нь хөндөлсөн хааж бурхан чанар олох боломжгүй болгодог байна.

**Гурав.** Дөрвөлжин орчин дахь хүмүүс ихэвчлэн цөм хамрын үзүүрээ харсан хар амиа хоохойлогчид, мөнгөнд хөтлүүлэн хувь хувийнхаа эрх ашгийг хөөцөлдөн яваа болохоор улс үндэстэн эх орон, элгэн садан хэмээн энэрч, дээдлэн сэтгэгчид өдөр ирэхүйеэ цөөрөх хандлагатай болоод байна. Үүнээс аварч чадах бурхан мэндэлсэн гэж үү?

**Дөрөв.** Цаг мөчтэй уралдан шинэчлэгдэж байгаа шинэ техник мэргэжлээр өвч биеэ зэвсэглэсэн дөрвөлжин соёлтонгууд амандаа “Байгаль орчныг хамгаална” гэсэн маань уншчихаад хэрэг дээрээ байгаль орчныг нэн хохируулж агаар мандлын бохирдлыг цаг ямагт хүндрүүлсээр эх дэлхий хэмээгч амьтан ургамлыг ивээн тэжээгч энэрэл хайрт ээжийнхээ цээж рүү сүх далайж, хөхөж идээшдэг хоёр мээмийг нь огтолж идчихээд бас ханалгүй арга бүхнийг сүвэгчлэн цусыг нь сорж, ясыг нь мөлжсөөр байна. Амьд бодис амьтан төрөлтөн дан ганцаараа сөнөөж орхихыг эцэг тэнгэр, этүтэн эх өршөөнө гэж үү? Үүнийг хориглон зогсоож чадах хүчин хүн төрөлхтөнд байгаа бил үү.

**Тав.** Эх хүйстэн бол энэрэл нигүүлсэнгүйн бүрэлваа нийт хүн төрөлхтний бие махбодийг төрүүлэгч, ивээн тэжээгч, энэрэн хайрлаж хүмүүжүүлэгч, мөн бөгөөд хүмүүсийн сэтгэл оюуныг гийгүүлэгч наран билээ. Иймээс эх хүйстэнд хамгийн дээд, хамгийн хүндэтгэлтэй байр суурийг олгож тэдний сэтгэл оюунд ямар ч хир буртаг хүргэхгүй байх ёстой. Гэтэл дөрвөлжин орчинд эх хүйстэнд бол эрэгтэй хүн мөнгөөр үнэлэн наадагч таваар, эр хүнд цэвэр цусан барилдлагатай хүүхэд төрүүлэгч багаж, гоёл чимэглэлийн эдээр бүрсэн тогтоом болжээ. Энэ нь ээжийгээ элсээр арилжиж

аавыгаа аргалаар сольсон хэрэг биш үү? Эх хүйстэнээр наадна гэгч ээжээрээ наадсантай аяглал нь юу вэ?

**Зургаа.** Хамгийн гол нь дөрвөлжин соёлын орчинд хүмүүс “би, би, би” хэмээн биеэ өргөж өөрийгөө зөвтгөж ”дөрвөн сэжүүр”-тэй төлөвшсөн байдаг учраас улс төр, аж ахуй, ахуй амьдралын цар хүрээ бүхэнд эе эвээ зохицуулан, эвлэрэн нягтарч, хичээн оршиж чаддаггүй. Тэр ч бүү хэл хоорондоо дандаа өшилцөн хорсолцож, өрсөлдөөн тэмцэлдэж нэг нэгнээ хохируулах цаашилбал аллага хядлага дайн байлдаан үүсгэх зэрэг муугийн муу ухааныг шүтдэг. Иймээс дөрвөлжин орчинд хэрэг явдалд санал нэгтэй хандах тохиол маш ховор. Тухайлбал хүний тухай томьёололыг үзсүгэй.

**Хүн бол энтропийг барагдуулагч**

**Хүн бол нүүрстөрөгчийн атомын хасах цэнэг**

**Хүн бол одны цөмийн үрс**

**Хүн бол хоёр хөл, соргог хараа ажилч гар**

**хөгжингүй ноён тархитай зэрэг шинжийг хуримтлуулагч**

**Хүн бол соёлыг хуримтлуулагч, тоосгон савыг үүдэгч тариа таригч,**

**бичгийг үүдэн бүтээгч**

**Хүн бол маш будлиантай сонин тархитан, сэтгэхүй ба хийсвэрлэх**

**чадвартай, өвөг дээдсээсээ төрөлх чанар, сэрлийн чадварыг**

**залгамжлан авагсад**

**Хүн бол харъяалагдаж бүхий нийгмээ бүтээгч**

**Хүн бол амьтны төрөлтний доторх хамгийн цэцэн нь**

**Хүн бол цорын ганц ичгүүрийг мэдэгч буюу, мэдэхийг хүсэгч амьтан.**

**Хүн бол нийгмийн харьцааны нийлбэр.**

**Хүн бол дээд төрөлтөн.**

**Хүн бол эх дэлхий дээр дэлгэрсэн хамгийн гоё цэцэг.**

**Хүн бол дэлхий дээрх хамгийн эрхэм нандин эд эрдэнэс**

**Хүн бол наадаж чадагч амьтан.**

**Хүн бол үг ярьж чаддаг амьтан.**

**Хүн бол орчлон ертөнцийн сүнс.**

**Хүн бол зөв бурууг ялгаж чаддаг амьтан.**

**Хүн бол бодисыг бүтээгчдийн доторх ноён.**

**Хүн бол ёслол, журам, итгэл, бат, оюуны таван чанарт амьтан.**

**Хүн бол түмэн бодисын сүнс, бас ч түмэн хорын үндэс**

**Хүн бол хүн шүү дээ, өөр юу ч биш**

**Хүн бол өөрийнхөө муу муухайгаа огт мэддэггүй.**

**Хүн бол өөрийгөө үхэл рүү хөтлөгч**

**Хүн бол ижил нэгтнээ хорлон хөнөөгч**

**Хүн бол амьтны ертөнц дэх хамгийн үнэ өртөггүй хог новш**

**Хүн бол хамгийн мунхаг амьтан**

**Хүн бол зууны зуугаар адгуусанд хүрэхгүй амьтан**

**Хүн бол бие, сэтгэлээрээ чөтгөр шулмас.**

Хүнийг араатан гэхэд араатныг бас арав дахинаар доромжилсон хэрэг болно гэх мэт. Энэхүү олон тооны тодорхойлолт нь чухамхүү дөрвөлжин соёлтонгуудын “Гайхамшиг” мэргэн “бүтээл” гэлтэй. Үүнийг чухам хэдэн

эшт онол гэх билээ. Хүн нүүр, нүүрээ харан оршиж түмэн оныг туулаад одоо болтол нэгдэлтэй санал гаргаж эс чадсан нь хүн гэсэн нэрээ гутааж байгаа хэрэг биш үү? Иймэрхүү “соёл”-ын энэ мэт төвшнөөр хүн төрөлхтнийг жинхэнэ дээд төрөлтөн, бурхан чанартан болгож чадах уу?

Үнэндээ “Хүн бол хүн шүү дээ, өөр юу ч биш” гэдэг хэллэг махбодь цогцосын хувьд үнэнд ойртож байгаа боловч амьдрал ахуйд араатан амьтнаас долоон дор юмс зөндөө байдаг болохоор “хүн” гэгчийг нэг хоёр үгээр томъёолоход бас хэцүү юм. Тийн авч далан долоон зүйлээр томъёолчихоод дал наян оноор маргаж мэтгэлцээд баймаар хэрэг бас биш дээ.

Хүний аливаа үйл явдал цөм зохих соёлын цар хүрээнд явагддаг учраас хүнийг заавал соёлт орчин дахь үг яриа, хамгийн гол нь үйл ажиллагаагаар нь баримжаалан томъёолох хэрэгтэй. Мэдлэгийн соёлын төвшинөөр авч үзвэл хүн бол амьтны чанар, хүний чанарыг хамтад нь агуулан яваа цогцос мөн. Аль чанар нь ноёрхох байрыг эзэлж тэрхүү цогцсыг эзлэн явж байгаа бол тэр нь гэсэн үг. Оюуны соёлын төвшинөөр авч үзвэл өнгөний хүн, чанарын хүн буюу сэрэл мэдрэлийн хүн, оюуны хүн хэмээн томъёолж болох юм. Гэтэл хүн бол соёл болон цогцос буюу оюуны болон бодис (махбодь, цогцос)-ын арга билгийн маш нарийн шүтэлцээгээр амь насаа тээгч онцгой төрлийн бодгаль болохоор хүнийг хэрэв оюун сүнснээс нь салгачихвал ямар ч үнэ өртөггүй босоо мах болчихно. Өөрөөр хэлбэл, хүн бол оюун сүнсэндээ хөтлөгдөн яваа амьтан болохоор хүнийг гагцхүү түүний үйл явдлаар нь баримжаалан томъёолол гаргах хэрэг. Өөр нэг утгаар нь хэлбэл хүн бол бурхан чанар) жинхэнэ хүн чанар) чөтгөр чанархоёулыг агуулан явагч мөн. Амиа хичээх, атаархах, шунах сэтгэл, хорт санаа, алив бурангуй үзлийг эрс тэс тэвчин дотоод сэтгэлээ цаг ямагт ариусган чадагсдыг бурхан чанартан, хар амиа бодож хорт муу санаа өвөрлөн бусдыг хохируулж хөнөөх муугийн муу ухааныг шүтэгчдийг чөтгөр чанартан хэмээн оношилж болох боловч хүн бол цаг ямагт хувьсан бүхий түүхэн хөдөлгөөнд үг яриа үйл ажиллагаа- (бие, хэл, сэтгэл)-раа өөрийн үнэ өртгөө үзүүлж явдаг болохоор энэ нь чөтгөр тэр нь бурхан хэмээн дураар оношлох нь бас гэнэн хэрэг юм. Гагцхүү тухайн хүний үйлдэж бүтээсэн буюу эвдлэн сүйтгэсэн үйл хэргээр нь баримжаалан үнэлж түүхт дүгнэлт өгөхөөс өөр аргагүй юм.

Дөрвөлжин соёлтонгууд хүний тухай далан долоон зүйлээр хэлээд байдаг нь тус соёлын мөн чанар лугаа холбоотой юм. Дөрвөлжин орчны дөрвөлжин сэтгэхүйтэй хүмүүс бол дөрвөн сэжүүртэй зангуу, олон иртэй ооль мэт овор зантай байж өөрийгээ зөвтгөж биеэ тоохоос биш бусдыг дээдлэн зөв үг зөв явдлыг нь хүндэтгэж эе эвээ ололцон эвлэрэн нэгдэж чадал хүчээ гурамслах оюуны тэнхээ ерөөсөө сулхан байдаг. Тэд дандаа зөвтгөн бусдыг буруушаагаад байдгаас биш өөрийгөө гэгээнээр гэдэргүү тунгаан сэтгэх чадвар маш дорой юм.

Дөрвөлжин соёлтонгуудын юм бүхэн цөм мөнгөнд хөтлөгдөж байдаг. Тэр нь хэдийгээр залхууг залхааж, хойргыг хөдөлгөх идэвхитэй элбэг баялаг эд эрдэнэс шинэ мэргэжил тоног төхөөрөмж бүхнийг хүнд зориулан

хүмүүсийн ахуй амьдралыг тансаг болгодог боловч хүний оюуныг тэлэн дотоод ертөнцийг ариусган цэвэрлэх явдлыг ерөөсөө юманд үздэггүй. Бид махбодид тохиолдсон өвчин эмгэгийг эмчлэн засдаг “эмнэлэг”-ийн газар өвчтөнийг тэр дор нь эмчлэн засдаг байхад сэтгэл оюуны гэмтэл олж зарим нэг нь сүнсгүй босоо мах болсон атал түүнийг ямар ч өвчин, тахалд нэрвэгдсэнд тооцдоггүй бөгөөд эдгээрийг эмчилдэг “эмнэлэг” ч байдаггүй. Иймээс дөрвөлжин соёлыг оюуны соёлын төвшнөөр баримжаалан үзэхэд хүрвэл ямар түвшинд байгаа нь тов тодорхой биш шүү!

Монголын өндөрлөгийн нүүдэл соёл бол үүнтэй шал өөр соёл юм.

Монголын өндөрлөгийн дугуй нүүдэл соёлыг хураангуйлаад монгол нүүдэл соёл товчоор нүүдэл соёл гэдэг. Хүн төрөлхтний ихэнх түүхэн үндэстнүүд нүүдэллэн амьдарч өнгөрсөн боловч монгол нүүдэл соёл мэт системжин төгөлдөржиж ид хаваа гайхуулсан нүүдэлчин үндэстэн ерөөс гараагүй билээ.

Үндэстний соёл бол тухайн үндэстнийх нь сүлд сүнс орших орон, оюун санааны түвшний хэмжүүр мөн. Монгол нүүдэл соёл нь орчлон ертөнцийн захирах захирагдах хатуу хуулийг чандлан сахиж эцэг тэнгэр, эх дэлхийгээ цаг ямагт бурханчлан шүтдэгээрээ тэнгэрлиг соёл, билиг оюун, баатар цөс хосолсон хүнийг “бүтээж” нийгмийг бүрэлдүүлдэг, эх хүний нийгэм дэх захирах байрыг дээдлэн шүтдэг жинхэнэ хүн соёл, хүний нийгэм дэх хэрэгцээ бүхнийг хангагч ачтан, шүтлэг бишрэлд түшиглэн сэтгэл оюунаа ямагт ариусган цэвэрлэж, мянган цээрийн ёсоор бие биенээ барьж явдаг шүтлэгт соёл, амиа хичээхийг жигшин юм бүхэнд бусдыг дээдлэн ачийг хариулан тусыг хүргэхэд үхэхээс үл буцдагаараа ариун соёл юм. Иймээс монгол нүүдэл соёл бол адилтгашгүй танин мэдэхийн ухаантай зүйрлэшгүй биечлэн бүтээх чадвартай соёл, өөрөөр хэлбэл цаглашгүй ялгуусан хүчинтэй жинхэнэ оюуны соёл мөн. Тэр бол монголын өндөрлөгийн өргөн уудам тал нутаг, өнөр баялаг уул ус-байгаль ээжийн элгэн дээр ариун цагаан сүүний шим, агт хүлгийн дөрөөн дээр, ажил хөдөлмөрийн үрэн дээр үндэслэн цэцэглэсэн хамгийн гоё цэцэг юм. Дугуй соёл гэдэг нь хөх тэнгэр нь хөмөрсөн тогоо мэт бөмбөгөр хөвөө хязгааргүй тал нутаг нь ч дугуй тойрог өргөө гэр, тогоо тулга, хүрээ буудал, ав хоморго, дайн байлдаан, овоо тахилга, хурал цуглаан цаашилбал малын хороо хашаа хүртэл цөм дугуй хэлбэртэй байдгаас болсон юм. Дугуй хэлбэр нь дэлхийн бөмбөрцгийг багтаасан одон гаригын хэлбэртэй адилхан байдаг ба түмэн бодисын уг хэвтэй төсөөтэй байдгаар онцлог юм. Бодисын хөдөлгөөнд дугуй хэлбэр нь дөрвөлжин хэлбэрээсээ бат бөх уян хатан элдэв даралтыг тэсвэрлэх чадвар нь дөрвөлжин хэлбэрээс хол давуу байдаг. Хамгийн гол нь иймэрхүү байгальлаг дугуй орчинд өсч хүмүүжсэн монгол хүний сэтгэхүйн загвар, оюуны төлөвшил нь ч дугуй загвартай болдог. Тухайлбал дөрвөлжин соёлтонгууд хавтгай буюу шулуунаар сэтгэдэг байхад монголчууд харин хөндлөн голдуу дөрвөн зүг найман зовхис дээр доор бүхнийг багтаан бөөрөнхий буюу босоогоор сэтгэж чаддаг.

XIII зуунд Чингис хаан болон түүнд, эргэлт буцалтгүй зүтгэсэн үй олон билиг оюун баатар цөс хосолсон дайчдыг төрүүлж өсгөсөн соёлын онцлогийг товчлон хураангуйлбал:

### **Нэг. Шүтлэгийн ухааны дээд хэлбэр тайлга тахилгын ёсон**

Нүүдэлчин монголчууд бол орчлон ертөнцийн харилцан түшилцэж шүтэлцэн, харилцан нөлөөлж эе эвийн ёсны маш нарийн зохицлоор дэв зэрэгтэй мөн захирах захирагдахын ёсоор орчин бүхий түгээмэл хуулийг маш гүн ойлгож тэнгэр газар өвөг дээдсийн онгон шүтээн юугаан бурханчлан шүтэх аргаар зохицуулан оршдог. Энэхүү зохицуулал нь ямагт тайлга тахилгын үйл болон цээр хоригын ёсоор биелэгддэг. Эсгий туургатны тайлга тахилгын ёсон бол системжсэн гүн нарийн утга агуулгатай, тогтсон цаг цаглабартай дэс дарааг сольж үл болох утгыг орхигдуулж үл болох чанга хатуу дэгтэй. Ордос нутгийн Эзэн хороо дахь Чингис хааны хараа ихэт хар сүлд, онгон шүтээний тайлга бол даруй нийт эсгий туургатны дунд шигшигдэн төлөвшсэн цорын ганц хамгийн дээд хаан бөөгийн ёсон болно. Энэ нь найман зуу гаруй жил тасалдалгүй өвөл зуны дөрвөн улирал, өдөр шөнийн 24 цаг босоо манаатай, болсон махан тахилгатай, мөнх бадарсан зултай өдгөө хүрсэн нь даян дэлхийд ганцхан билээ. Энэ цог жавхаа бадрангуй тайлгын ёслолыг биеэрээ үзсэн харийн нэг эрдэмтэн гярхай нүд мэргэн ухаанаараа тунгаагаад гайхаж цочих, биширч эмээх сэтгэлгээр “Нийт монголчуудын оюуны шижмийг нэгтгэн авч дахин мандуулж мэдмээр аймаар сүрхий үйл ажиллагаа байна” хэмээн үнэлсэн ба хятадын гүн ухаантан Еань Чунюй, Ван Цунзи нар “Чингис хаан бол тэнгэртэй ямар нэгэн холбоотой хүн” гэж өгүүлсэн билээ. Нүүдэлчин монголчууд өдгөө ч гэсэн гол мөрний орчим бие засдаггүй, хог новшийг хамаа намаагүй хаядаггүй эх дэлхийгээ унаган төрхөөр нь хамгаалж хайрлаж явах нь ард нийтийн ёс журам болчихсон байдаг. Тэд нар уул ус хад хайрхнаа онголон дархалж тогтсон өдөр нь тайж тахидаг. Энэ нь нүүдэлчин монголчуудын тэнгэрлиг чанарыг харуулсан хэрэг биз ээ. Мөнх тэнгэр онгон шүтээний нарийн ёсыг “Ерөнхийн шүтээний тайлга тахилга” номд нарийн бичсэн билээ.

### **Хоёр. Аргын ухааны дээд хэлбэр эе эвийн ёсон**

Нүүдэлчин монголчууд эрт дээр үеэс “Амь мянган лан, арга түмэн лан” хэмээн аргын ухааныг дээдлэн шүтэж юу ч мэдэхгүй юу ч чадахгүй хүнийг “Аргаа барсан амьтан” хэмээн үздэг байжээ. Эе эвийн ёсон бол орчлон ертөнцийн оршин тогтнолын түгээмэл зүй, монгол ухааны үндсэн арга барил мөн. Эеийг олох нь хэрэг бодисыг танин мэдэж, эвийг нь тааруулах нь үйл явдлыг хийж бүтээх явдал мөн. Эе эвийн ёсыг өдөр тутмын амьдрал айл саахалтын хооронд, хүний ертөнц хийгээд эцэг тэнгэр эх дэлхий болон амьтан ургамал байгаль орчны харьцаанд нэг үгээр хэлбэл орчлон ертөнц шүтэлцэж бүхий мөнхийн зүйг ёсчлон биелүүлж болдог. Тэрчлэн физик, хими, тоон ухаан ялангуяа бүтээлч хөдөлмөрт нэн дутагдашгүй юм. Өдгөөх сансарт нисч саранд авирагч хөлөг онгоц ч мөн эе эвийн дээд зохицлоор бүрэлдсэн эд гэгчийг хэн ч мэднэ. Чингис хааны ид шид шингэсэн

гайхамшигт чадавхийн үнэн оньс нь ч цэрэг ардаа багтаасан тэнгэр шүтлэг, түүний аргын ухаан-эе эвийн ёсыг маш чадамгай хэрэглэсэнд оршино.

### **Гурав. “Нэгэн жолоонд” байлгах онол**

Нэг толгой есөн сүүлтэй, есөн толгой нэг сүүлтэй могойн үлгэр хийгээд Алунгоо эхийн таван мөсөөр үлгэрлэсэн нэгдэн нягтрахын дээд шаардлагыг Чингис хаан биеэрээ үлгэрлэсэн юм. Ингээд “Эвт шаазгай буга барина” гэгчээр шүтлэг мөргөлөөр хүмүүсийн оюуны шижмийг гурамслан авч цэрэг ард даяар элгэн саднаас илүү нягтран нэгдэж цөөхөн монголчууд “Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг” болж чадаад тухайн үеийн түүхэн тавцан дээр их нэгдлийн агуу их жүжгийг тоглож тэнгэрлиг үйлийг бүтээн монгол үндэстнээ тэнгэрлэг үндэстэн болгон бүрэлдүүлж чадсан байна. Нэг үндэстэн, нэгэн улс гүрэн зөв зорилтыг сонгон авсан тохиолдол дор бүх ард түмний оюун санааг “нэгэн жолоонд” оруулж чадах эсэх нь ялж ялагдах мандах буурахын зангилаа асуудал болно. Үүнийг огоорогсод ямарч үйлийг бүтээж чадахгүй юм.

### **Дөрөв. Эрдэнэт биеийг төрүүлж өсгөсөн эхийгээ шүтэх**

Нүүдэл соёлын эх шүтлэг бол амьтан ургамал бүхнийг төрүүлж, тэжээж, ачаалан тээж яваа эх дэлхийгээ шүтдэг мэт эх хүйстнээ ч голомт сахидаг гол шүтээн-галын бурханы байрд дээдлэн шүтсэн явдал юм. Нүүдэлчин амьдралд эх хүн бол эх соёлынх нь гол ачаалагч өвлөн залгамжлуулагч хүүхдүүдийнхээ дэргэд байнга хамт байж бие, хэл, сэтгэлээрээ үлгэр дууриал болгон хүмүүжүүлэгч хамгийн сайн багш юм. “Эх нь хээр алаг бол, унага нь шийр алаг” гэж эхийн чанар чансаа үр хүүхдийн мөс чанарыг шууд тогтоодог гэсэн үг. XIII зууны нүүдэлчин нийгэмд их дунд сургууль байтугай, бага сургууль ч байгаагүй билээ. Монголчуудын хүмүүжил хүртдэг цорын ганц сургууль бол ээж багштай гэрийн сургууль юм. Монгол эхчүүд бэлэвсэрсэн тохиолдолд ч “Хар гэрээс хаан бор гэрээс богд” хүмүүжүүлж чаддагийг Алунгоо эх, Өүлэн эх, Сорхугтаны эхийн жишээ бидэнд харуулж байгаа. Нүүдэлчин монгол эхчүүд үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлдэгийг цухас дурдвал эх хүмүүс хэрхэн шүтэгдэх байр суурьтай байдагийг ойлгоход нэн тустай юм.

Нэгд, “хар гэр, бор гэр гэдэг нь ерийн гэр гэсэн үг. Гэрийн хүмүүжил бол монгол гэрээр хичээлийн танхим болгон явагддаг хүмүүжил юм. Монгол нүүдэл соёлыг тэр чигээр нь өвлөн авч яваа түүхэн дэх баруун гурван түмний нэг нь одоох Өвөрмонголын ордос нутгийн зургаан ханатай гэр 95 уньтай байдаг. Тооно нь тэнгэр буюу тэнгэрийн хөвгүүн-хаан Чингис, унь нь Чингисийн 95 мянганы ноён 6 хана нь тохой тохойгоо холбосон цэрэг ардын бат барилдлага гэдэг, монгол гэрийн бүтэц бол монгол төр, нийт монгол туургатны бүтэц болно. Энэ эе эвийн барилдлагаар бүтсэн бүтэц бол бүхэл нь хэсэгтэйгээ, хэсэг нь бүхэлтэй, хэсэг нь хэсэгтэйгээ цөм түшилцэн шүтэлцэж оршдог мөнх тэнгэр-орчлон ертөнцийн бүрэн авалцаат бат барилдлагыг илтгэсэн гүн ухаан (монгол ухаан)-ы хамгийн дээд хураангуйлал болно. Иймэрхүү хүн, гэр айл, төр гурвын монгол оршихуйн эе эвийн

зохицол алдагдвал тэнгэрийн зүйг зөрчсөн хэрэг болж гэр нь гэр болж чадахгүй, төр нь төр байж чадахгүй, монгол нь монголоороо байж чадахгүй болно гэсэн хатуу хуулийг илтгэсэн байдаг. Нүүдэлчин монголчууд монгол гэр дотроо хүүхэд багачууд төдийгүй хүн бүхэн төрөө өндөр төвшинөөр дээдлэн үзэж өөр өөрсдийн орон зайгаа олж амьдрах байнгын хүмүүжлийг хүртдэг. Харамсалтай нь дөрвөлжин соёлд автагдсанаас уламжлалт соёлоо мартаход хүрч амсаж үзээгүй гай зовлонг амсаж өнгөрсөн билээ. Тухайн үеийн монголчуудын хүүхдийн тоглоом наадмууд нь ч тоо, физикийн ухааны гүн нарийн утга агуулгатай, үлгэр домог, ерөөл магтаал, зүйр цэцэн үг ардын дуунууд нь ч цөмөөрөө гүн ухааны гүн нарийн утгатайг дэвтэр дэвтрээр хэвлэгдсэн номууд давхар давхар нотлож байгаа билээ.

**Хоёрт,** эх хүний байр суурь хэр тэнцсэн хүний бүтээгдэхүүнийг нийгэмд төрүүлдэг зэргийг дээр бичсэн тул давтахаа больсугай.

**Гурав,** нүүдэл соёл бол байгальлаг чанарын эзлэхүүнээр дийлэхгүй болохоор тэрхүү энэрэлгүй хатуу орчинд бие сэтгэлийн чадал тэнхээ, цаашилбал оюуны тэнхээгүй хүн оршин амьдрах боломжгүй болохоор хүний чанар чансааг юунаас ч эрхмээр үзэж байсан нь илхэн. Хэрэв чадал тэнхээгүй хүнийг өсгөвөл дайнд явбал алагдах, ан авд явбал араатан амьтанд идэгдэх, аагим халуунд хатаж цангаж үхэх, хахир өвөл хөлдөж үхэх аюулаас зайлж үл чадна гэдэг нь хэнд ч ойлгомжтой билээ. Энд ганцхан архи цээрлэдэг ёсыг дурьдсугай. Нүүдэлчин монголчууд архи уухыг хатуу цээрлэж байжээ. “Дөч хүрээд дөнгөж амс, тавь хүрээд тааруулж балга, жар хүрээд жаргаж хүрт” гэдэг нь цөм үр хүүхдээ архинаас сэрэмжилсэн хэрэг ажээ. Учир нь архи уусны дараа олдсон хүүхэд нь усан тэнэг, мэдрэл муутай, юу хийхээс ч буцахгүй амьтан болчихдог. Үүнийг өнөөгийн шинжлэх ухаан ч дахин давтан нотолсоор байгаа билээ. Иймээс архичингууд бол нэг цагийн согтуугаар нэг насны согтууг үйлдвэрлэн гаргагч, өөрөөр хэлбэл гэмт хэрэгтний эцэг нь гэсэн үг. Иймээс хувь хүн энэ асуудлыг огоорвоос овог үндэс тасрах, нэг үндэстэн энэ явдлыг огоорвоос утсаагаараа мөхөх, нийт хүн төрөлхтөн энэ асуудлыг огоорвоос хүний нийгэм ямарч гарах зам байхгүй болно гэсэн үг.

Нүүдэл соёлын тухай товч бичсэн нь энэ буюу. Өдгөөх ертөнцийн тухай цухас дурдсу.

## 2.ЭДҮГЭЭ ЕРТӨНЦ БИДНИЙ ОРШИН БҮХИЙ ЦАГ ҮЕ

Цаг үеийг оновчтой танин мэдэх эсэх нь тухайн соёлын гүн ухаан ч чанартай шууд холбоотой байдаг. Цаг үеэ зөвөөр танин мэдэж чадвал өөрийн оршин амьдрах орон зайгаа зөв сонгон авч ямар ч байдалд ялагдашгүйгээр зорьсон зорилтдоо хүрч чадна. Ийм биш бол сэтгэшгүй төөрлөөр мунгинах л хэрэг. Тэгвэл бид эдүгээ ямар цаг үед оршиж байгаа вэ? гэвэл бид эдүгээ яг дэлхийн гуравдугаар их дайны туйлын хурц ширүүн явцад оршин байна. Энэ дайн нь заримдаа зэвсгийн хүчээр явагдаж буй боловч хамгийн өргөн дэлгэр нь босоо орон зайд зэвсгийн бус хэлбэрээр явагдаж байна. Энэ дайн дэлхийн хоёрдугаар дайн дууссан тэр өдрөөс эхэлсэн бөгөөд дайнд ялагдагсад нь

дахин ялалтын байрд шилжих хэлбэрээр даян дэлхийд ил тод харагдвай. Энэ нь даруй техник мэргэжлийн тасралтгүй шинэчлэлтээр зэвсэг болгосон аж ахуйн, бараг хүн бүхнийг хамран оруулсан хурц ширүүн мөртлөө том дайн буюу. Өөрөөр хэлбэл зах зээлийн эдийн засаг хэмээх нэрийдэл дор техник мэргэжлийн зэвсгээр явагдаж байгаа дайн болно. Үүнийг харахуйяа аж ахуйн дайн мэт боловч үнэн хэрэг дээрээ энэ дайн бол соёлын дайн юм. Өөрөөр хэлбэл энэ дайн нь хүмүүсийн мэдэхүй чадахуйн үнэн үр өртгийг шалгаруулах хайр найргүй тэмцээн мөн. Энэ дайны онцлог бол тэрбээр дөрвөн зүг найман зовхис дээр, доор, дэргэд хол хэмээн ялгалгүй дэлхийн бөмбөрцгийг бүхэлд нь бүрхэн босоогоор явагдаж буй учраас хэвийн сэтгэхүйн буй бүхий зүйл цөм хайр найргүй таягдагдаж, улс үндэстний зааг цаашилбал улс улсын хоорондох зааг ч дэмий утга агуулгагүй юм болоод байна. Энэ дайны хамгийн эцсийн ялалт нь хэнийх болох вэ? гэвэл тэнгэрийн зүйг журамлан, хамаг юмыг халан нэг болгон хамтатгаж эцэг тэнгэр эх дэлхийг чин сэтгэлээсээ шүтэгч хатуу бясалгалаар сэтгэл оюунаа ариусган төгс төгөлдөр болгосон оюуны соёлтных болох юм.

Өдгөөх ертөнцийг өнгөн дээрээс нь авч үзвэл хүмүүсийн нүдийг эрээлжлүүлэн толгой эргүүлэм боловч оюуны соёлын баримжаагаар үнэлж үзэх юм бол даан ч нялхас мөртлөө ялимгүй төвшинд байгаа юм. Шуудхан хэлбэл одоох ертөнц яг” баасан бамбарцаг”-ийн төвшинд байгаа гэж хэлж болно. Хөдөө нутаг дахь морь, үхрийн баасан дээр цугларч малын баасаар амьжиргаагаа болгогч нэг зүйлийн хорхойг ”баарч хорхой” буюу “баасан бамбарцаг” гэдэг. Зарим газар бас “цох хорхой, “баасан ялаа” ч гэдэг. Эд нар баасны үнэрийг маш соргоогоор мэдэж хоромхон зуур хуран цугларч чадалтай нэг нь хоёул нийлж нэг бөөн баас бөмбөрүүлэн усанд үл автах өндөр шиг газар нүх малтаж ороод гэр бүл болж үр үндэс залгахаар ичээнд ордог бөгөөд дараа жил нь үрс нь гараад ирдэг. Чадал муутай залхуу нь баасан овоог тэр дор нь идэж дуусгаад өөр тийш баас хайн нисчихдэг. Нэг үгээр хэлбэл хойч үеэ өсгөхийн төлөө л биз. Өдгөөх мөнгөнд хөтлөгдсөн дөрвөлжин соёлтонгууд ч үүнтэй ав адилханаар мөнгөний сураг хаа байвал тийшээ нисч зарим нэг нь баас бөмбөрүүлсэн мэт том, жижиг дунд адил бус дэв зэргийн баячууд болчихоод дэлхийд гайхагдаж, ихэнх нь ямарч олборгүй ийш тийш ниссээр байгаад нэг насаа дуусгах буюу амь насаа золиослоод дуусдаг. Ялгаа нь юу вэ? гэвэл нэг нь баасыг шүтэж, нөгөө нь мөнгийг шүтсэн хэрэг. Энэхүү нийгмийн байгальч орчинд хүн хэдийгээр сарнаа авирч сансарт нисэх чадвартай болсон авч үүндээ өөрсдөө омогшиж бусдад сайшаагдсан “агуу бүтээл”-ийн ихэнх нь шувуу шаазгай хорхой шавьжнаас үлгэр авч бүтээсэн хэрэг төдий юм. Нийгэмч амьтны хувьд авч хэлбэл дэг журам сахиж эе эвтэй амьдрах талаар хүн төрөлхтөн өдгөө болтол хальст далавчтаны аймгийн балт зөгий шоргоолжны төвшинд ч арай хүрч чадаагүй агсаар. Дэлхийн аль нэг үндэстэн арьстны дунд ч гэсэн дайн дажин аллага таллага, худал яриа, хуурмаг мэхлэл, элэг нэгтнээ элдэв янзаар хохируулж хоргоож буй явдал үүнийг цаг ямагт давхар давхар гэрчилсээр байгааг эрүүл саруул сэрэл мэдрэлтэй бүхэн ажиж харж байгаа биз.

Тэгвэл оюуны мухардмал орчноос хэрхэн гарах вэ? гэвэл юуны өмнө өдгөөх хамгийн одоочилсон орчинд хамгийн үнэ өртөггүй хүн “бүтээгдэхүүн”-ийг үйлдвэрлэдэг туйлын хоцронгуй байдлыг үндсээр нь өөрчилж цаг эриний шаардлагыг хангаж чадах хүний “бүтээгдэхүүн”-ийг үйлдвэрлэх нөхцөлийг дав даруй бүрэлдүүлэхэд оршино.

**Нэг,** эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг үндсээр нь өөрчилж эрэгтэйчүүдийн эрхэнд өөрийн эрхээрээ бууж өгдөг дорой байдлыг эцэслүүлж, эх хүйстний дагина чанар буюу дарь эх чанарыг эрхшүүлэн бэхжүүлж нийгэм нийтэд шүтэгдэх байр суурьтай болгох.

**Хоёр,** хайр дурлал дахь байгальч чанар мөн тэнгэрлиг чанарыг ихэсгэн батжуулж эх хүмүүс цөм тэнгэрлиг үрс, Чингис хааны өрлөг жанжнууд болон мянганы ноёд, зууны ноёд хийгээд үй олон байлдагч мэт үндэстэн эх орныхоо төлөө халуун амь бүлээн цусаа цувруулахад цаг ямагт бэлхэн байдаг билиг оюун баатар цөм хосолсон хүний бүтээгдэхүүнийг улс орондоо хангадаг болгох.

**Гурав,** эх хүйстэн ялангуяа охид хүүхдийг мөнгөөр золиослон наадаж сэтгэл оюуныг нь бузардуулдаг үйл ажиллагааг хориглох арга хэмжээ авч ариун цагаан хөдөлмөрөөр нь амьжиргааны эх сурвалж болгодог болгох.

**Дөрөв,** нийгэм нийтэд ариун чанарын бясалгалыг өргөнөөр дэлгэрүүлэн сэтгэл оюуны хүчнийг тэлэн цэвэршүүлж хүний жинхэнэ хүн чанар мөн бурхан чанарыг нь батжуулах, үүнд аливаа шажин суртахууны сүм хийд, бясалгалын урсгал бүлэг чухамдаа цөм оюуны соёлын идэвхтэй хүчин байх ёстой билээ. Харамсалтай нь эдгээрийг эрхлэгч хутагт хувилгаад нь язгуурчлагдан доройтож цаг эриний шаардлагаас хол хоцорч нэр ашиг мөнгө зоосонд хөтлөгдөн дөрвөлжин соёлтон болчихоод өөр бусдыг хуурч мэхлэхээр барахгүй бурхан тэнгэрийг ч хуурч мэхлэн өдөр өнгөрөөж байгаа эд нарын үнэн худлыг нийгмийн практик түмний итгэлээр шалган үзэж үнэнийг бадруулан худлыг нь үнэн рүү хөтлөх идэвхтэй арга хэмжээг авах.

**Тав,** үр хүүхэд төрж өсгөх эрхийг жинхэнэ билиг оюун нээгдсэн сэцэн эх, сутаг эх хүмүүст олгохоос бус эм хүйстэн бүхэн хүүхэд төрдөг хэвийн сэтгэхүйг хувируулж төр нийгэмдээ дээд хариуцлага хүлээдэг болгох.

**Зургаа,** агаар мандал орчин ахуйн бохирдол бол цөм хүн өөрөөс нь болсон аюул түгшүүр мөн. Бусдыг үл өгүүлэн зөвхөн машин онгоц хоёроос цацаж гаргасан химийн хорт утаа агаар мандалд гучин сая тонн хуримтлагдаад байгаа нь хэрэв хүндрээд дэлхий дээр бууж ирвэл амьд үлдэх амьтан нэг ч байхгүй гэсэн дүгнэлтийг америкийн эрдэмтэд гаргасан байна. Ер нь хүн өөрөө бохирдлын эх сурвалж нь юм. Иймээс хүн өөрийн үйл ажиллагаа бүхэндээ эцэг тэнгэр, эх дэлхий, элэг нэгтэн, жич энэ биендээ дээд хариуцлага хүлээж ямарч бохирдол гаргахгүй амьдрахыг сахил болгон сахиж явах нь эрхэмээс эрхэм. “Агт хүлэгтэй аргалын соёл минь мөнхжсүгэй” хэмээн хэлмээр байна.

Долоо, дээд мэргэжил гэгчийн тухай. Одоо үеийн шинжлэх ухаанд дээд мэргэжил ноёрхох боллоо. Гэтэл бүх шинжлэх ухааны ололтууд хүн төрөлхтнийг чухам хааш юу руу хотлөн яваа нь ээдрээтэй байгаа нь нууц биш. Чухамдаа эх хүнээс цаг эриний шаардлагыг хангаж чадах билиг оюун нь нээгдсэн дээд зэргийн хүнийг төрүүлж өсгөх явдал бол сая хамгийн дээд мэргэжил мөн. Жирэмслэх цаг, хэвлий дэх хүмүүжил, гурваас таван насан дахь суурь хүмүүжил, хүүхдэд нааштай нөлөө үзүүлэх нийгмийн орчин зэрэг бол сургуулийн хүмүүжил хир зэрэг бүтэмжтэй болохыг шууд тогтоодог байна. Хэрэв өдгөөх балар бурангуй амьтад мэт ямарч сүжиг бишрэлгүйгээр жирэмслэх цагаа ч мэдэхгүй мунхаг “хайр дурлал”-ын бүтээгдэхүүнийг төрүүлж гаргачихаад амтат хоол өнгөт хувцсаар чимээд өсгөсөн юмс бараг зууны зуугаар хэрэггүй юм болж мэдмээр байна. Иймэрхүү юмсыг зөвхөн сургуулийн хүмүүжлээр хүн болгох гэгч даанч бэрх юм. Гүн ухааны талаар балай мунхаг, үйлдэл дээрээ чадал тэнхээгүй хүмүүс бол хамгийн аймшигтай байдаг гэснийг саруулаар тунгаагуштай юм.

Хүмүүс сар шинийн баяраар тансаг амьдралын дунд умбаж байгаа цагийг ашиглан яаравчлан таталсан зүйлс минь хүмүүст дөрвөлжин соёлын “хөгжил, дэвшил” гэгчийг үндсээр нь үгүйсгэн, хоцронгуй дорой “нүүдэл соёл”-оо хэт магтсан хоёр өрөөсгөл рүү өмхрөн орчихсон мэт сэтгэгдэл өгсөн боловч үнэн санаа нь тийм биш болой.

Миний гол зорилт бол хоёр төрлийн соёлыг нэн нягтаар уялдуулан нэг нэгнийхээ дутуу талыг хүчтэй нөхөн төгөлдөржүүлж өөрөөр хэлбэл нүүдэл соёлын оюуны хүчнийг дөрвөлжин орчинд нэн сайнаар үйлчлүүлэх нь эрхэм хэмээн санасан хэрэг буюу.